



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 03 өдөр


Дугаар А/39

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
2020 оны төлөвлөгөө батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.
2. Төлөвлөгөөний биелэлтийг тухай бүрт тайлагнаж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



**УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
2020 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020 оны 02 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцах хэлтэс	Хугацаа
1	2	3	4	5
1	Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	ЗУСХ, ЭБАТ	Жилдээ
		Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлагад суурилсан мерит зарчмыг баримтлан ажиллана.	ЗУСХ	Жилдээ
		Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэж ажиллана.	ЗУСХ, ДХХ	Жилдээ
		Ажилтан, албан хаагчдыг давтан сургах, мэдлэг мэдээлэл олгох чиглэлээр арга хэмжээ авна.	ЗУСХ, ЭБАТ	Жилдээ
2	Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэдэд хүргэх ажлыг үе шаттайгаар нэвтрүүлж ажиллана.	ЗУСХ	Жилдээ
		Албаны дотоод хяналтыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, дотоод удирдлагын системээр үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавина	ДХХ	Жилдээ
3	Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах	Албаны үйл ажиллагаанд хөндлөнгийн төрийн бус байгууллага хяналт тавих, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавьж буй үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.	ХХУЗХ, ХТЦХ	Жилдээ
		Албанаас зохион байгуулах улс, нийслэлийн төсөвийн хөрөнгөөр санхүүжих худалдан авах ажиллагааны явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнана.	ДХХ	Улирал бүр
4	Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	ЗУСХ	Хагас жил тутам